

ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАНДАРТЧИЛАЛ,
ХЭМЖИЛЗҮЙН ХЭЛТЭС



*2016 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН*

2016 он

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН
2016 ОНЫ I УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2016 оны 03 дугаар сарын 30

Сайншанд сум

Хэлтсийн даргын мэдэгдэл:

Тус хэлтэс нь Дорноговь, Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрт “Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай”, “Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай” хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүргийнхээ хүрээнд хэмжих хэрэгсэл болон бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт, стандартыг мэдээлэх, сурталчлах, хүргэх төрийн үйлчилгээний ил тод, шуурхай, хүртээмжтэй, чанартай байдлыг хангахад төрийн албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлэх, чадваржуулах, мэргэшүүлэхэд чиглэсэн удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.

Нэг: Удирдлага зохион байгуулалтын талаар

Хэлтэс нь Стандартчилал, хэмжилзүйн газрын даргатай бүтээгдэхүүн нийлүүлэлтийн “Үр дүнгийн гэрээ”, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Шинэ Дорноговь – 2” хөгжлийн хөтөлбөрт 2 заалт, мөн аймгийн Засаг даргатай бүтээгдэхүүн нийлүүлэлтийн “Үр дүнгийн гэрээ”-г тус тус байгуулан ажиллав.

Түүнчлэн Стандартчилал, техникийн зохицуулалт, бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаажуулалт, хэмжих хэрэгслийн талаар 2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган Стандартчилал, хэмжилзүйн газрын дарга болон аймгийн Засаг даргаар баталгаажуулан тухайн онд хэлтсийн хэмжээнд:

- **Стандартчиллыг хэрэгжүүлэх, хөгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх**
- **Хэмжилзүйн баталгаажуулалтын ажлын хүрээг өргөжүүлэх, нарийвчлалыг сайжруулах**
- **Хүний нөөцийн чадавхийг сайжруулах, мэргэшүүлэх гэсэн үйл ажиллагааны зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.**

Хэлтсийн 2016 онд дэвшүүлсэн зорилтынхоо хүрээнд сар бүрийн үйл ажиллагааг төлөвлөхдөө тус онд дэвшүүлсэн үндсэн зорилго, зорилтууд болон төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, хяналтыг дээшлүүлэхэд чиглэсэн уриагаа үр дүнтэй хэрэгжүүлэн, зохион байгуулж байгаа ажил арга хэмжээнд ажилтнуудын жигд оролцоог хангах, олон нийтэд чиглэсэн арга хэмжээг үр өгөөжтэй зохион байгуулахад анхааран ажиллалаа.

Тайлангийн хугацаанд хийсэн ажлуудыг тоймлон үзэхэд:

1. Хэлтсийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталж, 10 төрийн албан хаагчтай үр дүнгийн гэрээ байгуулж, төрийн үйлчилгээний ажилтнуудын үйл ажиллагааны төлөвлөгөөг хянан баталсан. “Стандартчилал, хэмжил зүйн төв, орон нутгийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн”-нд оролцож СХЗГ-ын дарга болон аймгийн Засаг даргатай 2016 оны үр дүнгийн гэрээ байгууллаа.

2. Байгууллагын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, түүний мөрөөр залруулах сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн, байнгын сайжруулалтыг хэрэгжүүлэх зорилгоор Хэмжилзүйн лаборатори, баталгаажуулалтын албаны 2015 оны үйл ажиллагааны тайланд дотоод аудит болон удирдлагын дүн шинжилгээ хийж, үр дүнгээр нь төлөвлөлт, тайлагналтыг сайжруулах арга хэмжээ авсан.

3. Мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг ханган, иргэдэд хэлтсийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол хүргэх зорилгоор байгууллагын www.masm.do.gov.mn сайтыг ашиглаж байна. Тус сайт болон Facebook хуудас, СХЗГ болон аймгийн цахим хуудаст хэлтсийн үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг байршуулж, цаг үеийн мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллалаа. Мөн орон нутгийн “DSB”, “MNT” телевизтэй хамтран ажиллаж, стандартчилал, хэмжилзүйн ажил үйлчилгээг сурталчлан таниулахад чиглэсэн арга хэмжээг зохион байгууллаа.

4. Тайлангийн хугацаанд хэлтсийн даргын Б дугаартай тушаал 4-ийг гарган баталгаажуулж мөн 25 албан бичиг хүлээн авч шийдвэрлэн, байгууллагаас 26 бичиг тоот төлөвлөн явуулж, 10 албан бичгийн 9 албан тоотод хариу хүргүүлсэн байна. Байгууллагад иргэнээс 1, ажилчдаас 5 өргөдөл ирсэнийг бүртгэн авч шийдвэрлэсэн байна.

Хоёр. Хууль, тогтоомжийн хэрэгжилт

Монгол Улсын хууль тогтоомж, УИХ, ЗГ-ын тогтоол шийдвэр, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах ажлыг хэрэгжүүллээ. Үүнд:

Шилэн дансны тухай хууль болон “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу мэдээллийг аймгийн цахим хуудсанд сар бүр байршуулан, олон нийтэд мэдээлж байна.

Авлигатай тэмцэх газарт хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан хаагчдын жагсаалтад орсон төрийн захиргааны ТЗ-5 ангилалд хамаарах 6 албан хаагч ХАСХОМ гаргахгүй болсон.

“Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль”-ийн хүрээнд худалдаа үйлчилгээний аж ахуй нэгжид тохирлын үнэлгээ хийж, 40 аж ахуй нэгжид тохирлын гэрчилгээ олгосон.

Монгол Улсын ЗГ-ын 143-р тогтоолын хэрэгжилтийг хангаж, Баталгаажуулалтын албаны мэдээллийн самбарыг шинэчлэн, байршуулсан. Мөн байгууллагын мэдээллийн самбар, төсөв санхүүгийн мэдээллийн самбарын мэдээллийг шаардлагатай тухай бүр шинэчлэж байна.

Салбарын тушаал шийдвэр, СХЗГ-ын даргын тушаалын хэрэгжилт:

Хэмжил зүйн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид “Хэмжил зүйн ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Шадар сайдын 2013 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 75 тоот тушаалыг баримтлан ажилласан.

СХЗГ-ын даргын 2013 оны А/23 тоот тушаалаар баталсан “Орон нутгийн стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн мэдээ, тайлан, боловсруулах, илгээх, журам”-ыг хэрэгжүүлж, 4 чиглэлээр мэдээ, тайланг заасан хугацаанд хүргүүлж байна.

Тус хэлтэс “Баялаг бүтээгчдийг дэмжих” жилийн ажлын төлөвлөгөө, “Хэрэглэгчийн жилийн” хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө, Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө тус тус гарган ажиллаж байна.

Гурав. Хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалт

Хүний нөөцийг хөгжүүлэх зорилгоор ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх, бие даан суралцах боломжийг бүрдүүлж зорилтот сургалтанд хамруулахаас гадна дотооддоо хууль эрхзүйн болон мэдлэг мэргэшлийн дээшлүүлэх, эрүүл, зөв амьдралын хэвшлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт мэдээллийг хийж байна.

Хэлтсийн төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, шилжилт хөдөлгөөн, хүний нөөцийн бүрэлдэхүүний талаарх дэлгэрэнгүй тайлан мэдээг гаргаж, заасан хугацаанд СХЗГ болон аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн.

Дөрөв. Төсөв санхүүгийн үйл ажиллагаа

- Тус хэлтэс нь 2016 онд нэгдүгээр улиралд **29259,6** мянган төгрөгийн төсөвт үйл ажиллагаа төлөвлөгдсөнөөс **28380,0** мянган төгрөгийн санхүүжилт авч **25636,1** мянган төгрөгийн зарлага гаргаж ажилласан ба **2410,0** мянган төгрөгийн өөрийн орлого төлөвлөгдсөнөөс **3677,3** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэв. Улсын төсөвт төвлөрүүлэх өөрийн орлогын төлөвлөгөөг 152,6 %-иар биелүүлсэн байна.

Одоогийн байдлаар байгууллагын хэмжээнд бусдад төлөх өглөг **4516,0** мянган төгрөг, **2166,2** мянган төгрөгийн авлагатай байна.


ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭС

- Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас байгууллагын 2014 – 2015 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж хогбогдох заавар зөвлөмж өгч ажилласан байна.
- Хэлтсийн ажилтнууд 2016 оны нэгдүгээр улирлын байдлаар албан томилолтоор давхардсан тоогоор 9 баяа 18 бийа ааеёёаагаг ааеёа. 7 үүг Улаанбаатар хотод 12 хоноа, сургалтаар 6 бийа, бөдөө орон нутаг руу 6 хоног явж ажиллав. Томилолтын зардалд **677,2** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **677,2** мянган төгрөгийн санхүүжилт авч **677,2** мянган төгрөгийг зарцуулсан байна.

Орлогын төлөвлөгөөг үйл ажиллагааны төрөл түс бүрээр нь хүснэгтээр харуулбал:

№	Баталгаажуулалтын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөөний биелэлтийг хувиар харуулбал
1	Тохирлын үнэлгээ	1200,0	1865,1	155,4
2	Цулын хэмжлийн баталгаажуулалт	900,0	1138,0	126,4
3	Цахилгааны хэмжлийн баталгаажуулалт	0	17,7	-
4	Эзлэхүүн хэмжлийн баталгаажуулалт	200,0	396,3	198,1
5	Стандартын салбар сан	110,0	260,2	236,5
6	Даралтын хэмжлийн баталгаажуулалт	0	0	-
Нийт дүн		2410,0	3677,3	152,6

Орлогын төлөвлөгөөг үйл ажиллагааны төрөл түс бүрээр нь графикаар харуулбал:



Тав. Үндсэн үйл ажиллагааны талаар

Дорноговь аймгийн Сайншанд, Замын-Үүд суманд баталгаажуулалтаар ажиллаж бүтээгдэхүүн, үйлчилгээ болон хэмжилзүйн баталгаажуулалтын ажлыг хэрэгжүүллээ.

Бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаажуулалтыг ажлыг Дорноговь аймгийн Сайншанд, Замын-Үүд сумдад тус тус хийлээ.

Баталгаажуулалтын ажлыг итгэмжлэгдсэн эрх бүхий лабораторитой гэрээ байгуулан сорилтын үр дүнг ашиглан иди иодаад эеёаудеуа ааеааа олнөөе аэдүүаауоэиā тохирлын үнэлгээ бөеа аāиуёо аабааг аадаёааааебөёа байна.

Шударга ёс, ил тод байдлыг эрхэмлэн иргэдэд хүнд сурталгүй үйлчилгээ үзүүлэх зорилгоор Баталгаажуулалтын салбар зөвлөлийг сум бүрт байгуулан хуралдаж, тохирлын гэрчилгээг газар дээр нь олгон, ард иргэдэд түргэн шуурхай үйлчилж байна.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭС

Тохирлын үнэлгээнд хамрагдсан бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар:

Дорноговь аймгийн Сайншанд, Замын-Үүд сумдад Баталгаажуулалтын салбар зөвлөл 5 удаа хуралдаж 40 аж ахуй нэгж, иргэнд тохирлын гэрчилгээ олгохоор шийдвэрлэж, газар дээр нь гэрчилгээ олгосон байна.

Баталгаажуулалтанд хамрагдсан үйлчилгээг төрөл тус бүрийг хүснэгтээр авч үзвэл:

№	Үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Аж ахуйн, нэгжийн тоо
1	Хүнсний дэлгүүр	ш	12
2	Баар караоке	ш	4
3	Дэн буудал	ш	-
4	Гуанз	ш	2
5	Ресторан	ш	4
6	Зочид буудал	ш	2
7	ШТС	ш	-
8	Хүнсний мухлаг	ø	4
9	Кафе	ø	2
10	Жуулчны бааз	ø	-
11	Интернэт кафе	ш	1
12	Биллъярдын үйлчилгээ	ш	-
13	Хүнсний биш бараа	ш	2
14	Хими цэвэрлэгээ	ш	1
15	Минимаркет	ш	2
16	Гэрэл зургийн үйлчилгээ	ш	1
	Нийт		37

Баталгаажуулалтанд хамрагдсан дотоодын бүтээгдэхүүнийг төрөл тус бүрийг хүснэгтээр авч үзвэл:

№	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Аж ахуйн, нэгжийн тоо
1	Хэрчсэн гурил	ш	
2	Вакум цонх	ш	
3	Бууз, банш	ш	1
4	Талх, талхан бүтээгдэхүүн	ш	
5	Цэвэржүүлсэн ус	ш	2
	Нийт		3

3.3 Экспортын бүтээгдэхүүн

№	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Аж ахуйн, нэгжийн тоо
1	Хэвийн боов, еэвэн	хайрцаг	2
2	Жонш	тн	1
3	Мөнгөний хүдэр	тн	1

ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭС

4		
5		
	Нийт	4

Стандартын салбар сангийн үйл ажиллагаа

Стандартын мэдээллийн салбар сангаас 8 аж ахуйн нэгж, байгууллага, иргэний захиалгын дагуу аж ахуй нэгж, байгууллага, иргэнээс ирүүлсэн стандартын захиалгыг үндэслэн нэрийн 20 стандартын борлуулалт хийж арга зүйн зөвлөгөө өгсөн.

Шинэчлэгдсэн болон шинээр батлагдсан стандартын талаар мэдээллийг тухай бүрт нь байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан, хамтран ажиллагч байгууллагуудын холбогдох ажилтнуудад цахим хэлбэрээр хүргэн, мэдээллээр хангасан.

Хэмжил зүйн ажил, үйлчилгээ

Хэмжилзүйн лаборатори нь худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, үйлдвэр, аж ахуй нэгж болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эзэмшилд ашиглагдаж байгаа жин хэмжүүр, туухай, цахилгаан болон усны тоолуур, шатахуун түгээгүүр зэрэг хэмжих хэрэгсэл баталгаажуулж, хэмжлийн үнэн зөв нэгдмэл байдлыг хангахад үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

Хэмжилзүйн лаборатори :

Монгол Улсын Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн дагуу орон нутаг дахь хэмжил зүйн хяналтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Стандартчилал, хэмжилзүйн зөвлөлийн 2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/19 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу хэмжих хэрэгслийн төрөл бүрээр баталгаажуулалт хийсэн.

Нийт /Дорноговь аймгийн хэмжээнд/ хэмжих хэрэгслийг баталгаажуулалтын төрлөөр нь багцалж хүснэгтээр харуулбал/

№	Хэмжлийн төрөл	Ажахуй нэгжийн	Иргэд	Төлөвлөгөө /хэмжих хэрэгслийн тоо/	Гүйцэтгэл /хэмжих хэрэгслийн тоо /	Гүйцэтгэлийн дүнг төлөвлөгөөтэй харьцуулан хувиар дүгнэвэл
1	Цахилгаан хэмжил	1	5		6	
2	Цул хэмжил	17	28		78	
3	Эзлэхүүн хэмжил	6	1		7	
4	Даралт					
				Нийт 91 ширхэг хэмжих хэрэгсэл баталгаажуулсан байна		

Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах ажил, үйлчилгээг өргөжүүлэх чиглэлээр арга хэмжээг авч цахилгаан тоолуур, хий шингэний эзэлхүүн, цулын зэрэг 9 төрлийн хэмжих хэрэгслийн чиглэлээр аж

ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийт **91** хэмжих хэрэгслийг хамруулж улсын баталгаажуулалт хийв.

Үүнээс задалж хэмжих хэрэгслийн чиглэлээр танилцуулбал:

Цахилгаан хэмжих хэрэгслийн баталгаажуулалт:

Сайншанд төмөр замын Эрчим хүч, ус хангамжийн 2-р ангийн цахилгаан тоолуурын лабораторитой хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний үндсэн дээр 1 ба 3 фазын 6 ширхэг Цахилгаан тоолуур улсын баталгаажуулалтад хамруулсан байна.

Нийт /Дорноговь аймгийн хэмжээнд ээлжит баталгаажуулалт/ хэмжих хэрэгслийг баталгаажуулалтын төрлөөр нь багцалж хүснэгтээр харуулбал:

№	Хэмжих хэрэгслийн төрөл	Дорноговь аймаг	Говьсүмбэр аймаг
1	1 фазын механик тоолуур	5	-
2	1 фазын цахилгаан механик тоолуур		-
3	3 фазын механик тоолуур	1	-
4	3 фазын импульс тоолуур		-
5	100 вольтын электрон тоолуур		-
6	100 вольтын импульс тоолуур		-
Нийт дүн		6	-

Цахилгаан хэмжүүрийн төрлөөр хэмжих хэрэгслийг шалгах ажиллагааг Төмөр замын ЭХУХ-ийн 2-р ангитай цахилгаан тоолуур засварлан тохируулах лабораторитой хамтран үйл ажиллагаанд хяналт тавьж, зохих стандартын дагуу баталгаажуулалтын ажлыг хийж гүйцэтгэж байна.

Хий, шингэний хэмжих хэрэгслийн баталгаажуулалт:

2016 оны 1-р улирлын ааеääàäð ðеé øеiäýíеé øýiæèð øýðýäñýе iеéð 7 øеðøýäеéä ääðäеääæóóеñäi.

Аймгийн Нефть хангамжийн баазтай байгуулсан гэрээний үндсэн дээр график, төлөвлөлтийн дагуу мөн аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Шатахуун түгээгүүрийн станцуудын хэмжих хэрэгсэлд улсын баталгаажуулалт олголоо.

Үүнд:

Шатахуун түгээгүүр 1, усны тоолуур 6 ширхэгдээ тус тус баталгаажуулалт хийсэн байна.

Нийт хэмжих хэрэгслийг баталгаажуулалтын төрлөөр нь багцалж хүснэгтээр харуулбал:

№	Хэмжих хэрэгслийн төрөл	Дорноговь аймаг	Говьсүмбэр аймаг
1	Шатахуун түгээгүүр	1	-
2	Автоцистерн		-
3	Шингэний тоолуур		-
4	Туузанметр		-
5	Денсиметр		-
6	Тосны хэмжүүр		-

ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭС

7	Усны тоолуур	6	-
8	Øèëýí ðýîæ¿¿ð		-
Нийт дүн		7	-

Цул, механик хэмжих хэрэгслийн баталгаажуулалт:

Дорноговь аймгийн нутаг дэвсгэр дээр худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй 17 аж ахуйн нэгж, байгууллага 28 хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эзэмшилд ашиглагдаж байгаа нийт 78 ш хэмжих хэрэгсэлд улсын баталгаажуулалтад хамрууллаа

Баталгаажуулалтанд хамрагдсан төрөл тус бүрийг хүснэгтээр авч үзвэл:

№	Хэмжих хэрэгслийн төрөл	Дорноговь аймаг	Говьсүмбэр аймаг
1	ВНЦ-10 жин	4	-
2	Эмнэлэгийн жин	10	-
3	ACS 15-30 жин	49	-
4	M3 ангийн туухай	12	-
5	TCS-100-300 жин	2	-
6	SCS-150 авто жин	1	-
7	Бусад төрлийн жин		-
8	Их даацын жин		-
ДҮН		78	-

Зургаа. Сургалт сурталчилгаа

- Сайншанд суманд зохион байгуулагдсан Дорноговь, Говьсүмбэр аймгийн хоёрдугаар тойргийн Тахарын албан хаагчдын нэгдсэн сургалт зөвлөгөөнд тус хэлтсийн баталгаажуулалтын шинжээч Х.Оюу-Эрдэнэ, Г.Шинэчимэг нар оролцож, өөрсдийн байгууллагын холбогдох хууль тогтоомжууд болон үндэсний болон олон улсын стандарт, Чанарын удирдлагын тогтолцоо /ISO 9001-2010 / - ны стандартын талаар анхан шатны ойлголт, мэдээллийг өгч ажилласан байна.

Энэхүү сургалтанд 25 төрийн албан хаагч оролцож, сонирхсон асуултандаа хариулт авчээ.

- Тус аймаг 2016 оныг Баялаг бүтээгчдийг дэмжих жил болгосонтой холбогдуулаад Дорноговь аймгийн баялаг бүтээгчдийн салбар хорооны анхдугаар сургалт, семинарын үеэр тэдгээрийн үйл ажиллагаанд шаардлагатай стандартын талаар, мөн бүтээгдэхүүний баталгаажуулалтын талаар тус хэлтсийн баталгаажуулалтын шинжээч Г.Шинэчимэг 170 гаруй аж ахуй нэгж, иргэдийн төлөөлөлд мэдээлэл хийж холбогдох асуултанд хариулт өгсөн байна.

Зорилтот сургалтанд ажилтнуудаа хамруулан мэдлэг чадварыг дээшлүүлэхэд анхааран ажиллалаа. Үүнд:

- СХЗГ-г зохион байгуулсан Итгэмжлэлийн үнэлгээний мэргэжилтэн бэлтгэх сургалтанд тус хэлтсийн баталгаажуулалтын шинжээч Х.Оюу-Эрдэнэ, Г.Шинэчимэг нар хамрагдаж гэрчилгээ гардан авлаа.

- СХЗГ-ийн Сургалтын төлөвлөгөөний дагуу Лаборатори итгэмжлэл, дотоод аудит, Лабораторийн итгэмжлэлд тавигдах шаардлага MNS ISO / IEC 17025 модуль -2 сургалтанд улсын шалгагч П.Энх-Отгон, Б.Түвшинжаргал нар хамрагдсан байна.

Долоо. Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах талаар:

Энэ онд аймгийн Мэргэжилийн хяналтын газартай хамтран ажиллах Санамж бичигт гарын үсэг зурж хамтран ажиллаж байна. Уг ажлын хүрээнд хэмжилзүйн талаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ:

Иргэд, худалдан авагчдыг буруу хэмжлийн сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх хяналт хийлээ.

Уламжлалт цагаан сарын баяр болж байгаатай холбогдуулан хүнсний худалдааны төв 5, хүнсний зах 2, хүнсний дэлгүүр 11-ийг хамруулан, худалдаа үйлчилгээний тооцоонд ашиглаж байгаа 58 хэмжих хэрэгслийн хэмжлийн нэгдмэл байдал, сав, баглаа боодолтой 20 гаруй нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний цэвэр тоон хэмжээ болон жин хэмжүүрийн лац тэмдгийг хөндөж, заалтыг өөртөө ашигтайгаар болгох, улсын баталгааны хугацаа дууссан жин хэмжүүр ашиглах, дутуу жинлэх зэргээр худалдан авагчдыг хохироож байгаа эсэхэд аймгийн МХГ-тэй хамтран урьдчилан сэргийлэх хяналтыг хийлээ.

Хяналт шалгалтаар улсын баталгааны хугацаа дууссан 13 худалдааны жинг баталгаажуулалтад хамруулан, 1-2 кг-аар савласан цагаан будаа, элсэн чихэр 20-50 гр-аар дутуу савлагдсан зөрчлийг газар дээр нь арилгуулав.

Иймд иргэд, худалдан авагч та бүхэнд буруу хэмжлийн сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх зорилгоор дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Үүнд:

1. Бараа бүтээгдэхүүний тоон хэмжээг өөрчлөх боломжгүй савласан эсэхийг шалгаж худалдан авах
2. Савласан, боосон, түүнчлэн ширхэгээр худалдаалагдаж буй бүтээгдэхүүний тоон хэмжээ нь сав буюу боодолд агуулагдаж буй бүтээгдэхүүний тоон хэмжээтэй таарч байгааг шалгаж авах
3. Улсын баталгаатай, лац тэмдэг, гэрчилгээтэй худалдааны жин дээр бараа бүтээгдэхүүнийг жигнэж тоон хэмжээг /кг, л/-г шалгаж байх
4. Ил задгай зөвшөөрөлгүй газар, гадаа гудамжнаас хэмжих хэрэгсэлгүйгээр баримжаагаар савласан хүнсний бараа бүтээгдэхүүн худалдан авахгүй байх.



Монгол Улсын Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн дагуу орон нутаг дахь хэмжилзүйн хяналтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн Зөвлөлийн 1999 оны 10 дугаар тогтоол, мөн Зөвлөлийн 1999 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хэмжих хэрэгслийн төрөл бүрээр баталгаажуулалт хийв.

Найм. Санал хүсэлтийн шийдвэрлэлтийн байдал:

2016 оны 1-р улиралд бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтаар Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газрын хүсэлтээр 18 аж ахуй нэгжид баталгаажуулалт хийв. Мөн Сайншанд суманд Аймгийн Баталгаажуулалтын зөвлөлийн хурлыг 2 удаа хуралдуулсан байна.

ТАЙЛАН БИЧСЭН: СХЗХ-ийн Баталгаажуулалтын шинжээч

Х.ОЮУ-ЭРДЭНЭ

ХЯНАСАН: СХЗХ-ийн дарга

Ш.ЭНХБАЯР

Зурагт тайлан

2016 оны 03 дугаар сарын 30

“ЦАГААН САР-2016” ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААГ
АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАВ





СТАНДАРТЫН МЭДЭЭЛЭЛ ӨГЛӨӨ





Сайнианд суманд ээлжит баталгаажуулалт хийв.

Бүтээгдэхүүн, үйлчилгээний газруудад тохирлын үнэлгээ, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтыг хэрэгжүүлээ.



АЙМГИЙН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ЗӨВЛӨЛ ТАВАН УДАА ХУРАЛДЛАА.



Хавсралт-1

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН 2016 ОНЫ 1-Р УЛИРЛЫН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

2016.03.30

№	Эрхзүйн актын нэр, Агуулга Огноо Дугаар: Заалт	Хэрэг жүүлэх байгуу лага	Хяналтанд байгаа заалтыг хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилтийн явц, гарсан үр нөлөө	Хүчингүй болсон буюу хяналтаас хассан тухай
Бодлого					
1.	МУЗГ Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2003.10.14 №222	СХЗГ	- Заавал баталгаажуулалтанд хамрагдаж бүтээгдэхүүн үйлчилгээний газруудыг баталгаажуулалтанд хамруулах - Стандартын талаар мэдээллэх	- Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 16.1-д заасны дагуу 2 сумын 37 худалдаа үйлчилгээ-/15үйлчилгээний ангилал/-ний газруудад баталгаажуулалтын үзлэг буюу тохирлын үнэлгээг мөрдвөл зохих стандартын шаардлагын дагуу хийж, худалдаа үйлчилгээний газрын мөрдвөл зохих стандартын шаардлагыг 80-аас дээш хувийг хангаж, үйлчилгээний чанар нь тогтворжсон 37 аж ахуй нэгж, иргэнд Баталгаажуулалтын салбар зөвлөлийн хурлын шийдвэрээр тохирлын гэрчилгээг олгон, тохирлын тогтвортой байдлыг ханган ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. - Шинээр болон шинэчлэн батлагдсан хүчингүйд тооцсон стандартын талаарх мэдээллийг estandard.mn вэб хуудас болон холбогдох байгууллагын ажилтанд цахим хэлбэрээр хүргүүлэн стандартыг сурталчлан, мэдээллэж ажилласан. Мөн 8 аж ахуй нэгж, байгууллагад 20 ширхэг стандартаар хангаж үйлчилсэн.	100.0
3.	Монгол Улсын Засгийн Газрын тогтоол Стандартчилал тохирлын үнэлгээний ажлыг боловсронгуй болгох зарим арга хэмжээний тухай 2005.06.14 127 Журмын 2.12, 3.8 –д	СХЗГ	заасан экспортын бүтээгдхүүнийг баталгаажуулалтын байгууллага тохирлын гэрчилгээ олгож болно	- Эхний улирлын байдлаар экспортын бүтээгдэхүүн 3 аж ахуй нэгжид 2 төрлийн (<i>мөнгөний хүдэр, жонши, хэвийн боов, эвэн</i>) бүтээгдэхүүнийг баталгаажуулан 4 <i>тохирлын гэрчилгээ</i> олгосон байна.	

4	<p>МУЗГ тогтоол Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах тухай 2009.05.14 № 143</p> <p><u>Нэг.</u> Үйл ажиллагаа-ны ил тод нээлттэй байдал 1.1 1.6 1.7</p> <p><u>Хоёр.</u> Хүний нөөцийн бодлогын ил тод байдал 2.4 2.6</p> <p><u>Гурав.</u> Төсөв санхүүгийн ил тод байдал 3.1-3.7</p>	СХЗГ	<p>Чиг үүрэгт хамаарах үйлчилгээний нээлттэй, ил тод шуурхай байдал хангагдсан байх</p>	<p>1.1 Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго тэргүүлэх чиглэл тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, төрийн үйлчилгээ үзүүлж байгаа мэргэжилтний өрөөний дугаар, бусад мэдээллийг агуулсан хаягийг шинэчлэн байрлуулж, үйл ажиллагаандаа мөрдөж буй хууль, тогтоомжийн холбогдох заалтуудыг хэлтсийн мэдээллийн самбарт тогтмол байрлуулан иргэд, үйлчлүүлэгчид тогтмол мэдээлж үйлчлэв.</p> <p>Мөн хэлтсийн ажлыг онцлог, сургалт, сурталчилгаа, арга зүйн зөвлөгөөг ажилласан сумдын байгууллага иргэдэд хүргэж ажиллав.</p> <p>1.6, 1.7 Иргэдээс гаргасан санал, хүсэлт өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч бүртгэн, холбогдох алба нэгжүүдэд хуваарилаж хуулийн хугацаанд шийдвэрлэх арга хэмжээг шуурхай авч хэвшснээр хэлтсийн ажил үйлчилгээтэй холбоотой санал, гомдолгүй ажиллаж байна.</p> <p>2.4 Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаархи сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас жил бүр авч, үр дүнг хэлэлцэн ярилцаж, шаардлагатай арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлж ажиллав.</p> <p>2.6 Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэл барьж ажилтнуудын үйл ажиллагааны үр дүнг нэгжийн хурлаар, дараагийн шатанд хэлтсийн дарга, нэгжийн менежер, төрийн албан хаагч хамтран хэлэлцэж үр дүнгээр нь эцсийн үнэлгээг өгч, холбогдох журамд заасны дагуу хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоод байна.</p> <p>3.1-3.7 Хэлтсийн санхүүгийн ил тод байдлын самбарыг батлагдсан загварын дагуу шинэчилж, журамд заасан жилийн төсөв, дунд хугацааны бодлого, зорилт, стратеги, үзүүлэх үйлчилгээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт, төсвийн гүйцэтгэл түүнд хийсэн аудитын дүгнэлт бүхий таван дэд хэсэг, 15 үзүүлэлт бүхий мэдээллийг шинэчилж байгаа байдалд байнгын хяналт тавьж ажилласнаар мэдээллийн самбарыг байнгын ажиллагаатай болгож хэвшүүлсэн.</p> <p>Ажил үйлчилгээний орлого болон бараа материал худалдан авах төлбөр тооцоог бэлэн бусаар хийх ажлыг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж, албан хаагчдад “Төсвийн</p>	100.0
---	--	------	---	--	-------

ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭС

				тухай хууль”, холбогдох санхүүгийн үйл ажиллагааны дүрэм, журмыг танилцуулан санхүүгийн зөрчилгүй ажиллах талаарх мэдээллийг хүргэж, зөрчил дутагдалгүй ажиллав.	
5	<p>Монгол Улсын Засгийн газрын тогтоол</p> <p>Монгол хэл бичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай 2013 он №37</p> <p><u>Нэг.</u> Тогтоолын 2 дугаар заалт</p>	Төр, төсвийн бүх шатны байгууллага	Албан хэрэг хөтлөлтийн соел, ажилт-нуудын хэлбич-гийн соел дээшилсэн.	2. “Монгол хэл бичгийн боловсролыг сайжруулах тухай “Засгийн газрын 2013 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 37-р тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Албан баримт бичиг боловсруулах арга зүй” гарын авлагаар хангаж, Стандартчилал, хэмжилзүйн газраас ирүүлсэн зөвлөмжийг төрийн албан хаагчдаар судлуулан албан хэрэг хөтлөх, бичиг баримт боловсруулахад мөрдөж ажиллав.	100.0
6	<p>МУЗГ-ын тогтоол</p> <p>Зуны цагийн хуваарьт шилжүүлэх тухай № 82</p>	Төр төсвийн байгууллага		Жил бүрийн 3 дугаар сарын сүүлчийн долоо хоногийн Баасан гарагаас Бямба гарагт шилжих шөнийн 02 цагаас эхлэн 9 дүгээр сарын сүүлчийн долоо хоногийн Баасан гарагаас Бямба гарагт шилжих шөнийн 00 цаг хүртэлх хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэрт цагийн тооллыг шилжүүлэх тогтоолын дагуу нэг цагаар урагшлуулан зуны цагийн хуваарьт шилжин, үйлчилгээ эхлэх цагийн хуваарийг хэвээр мөрдөж байна.	100.0

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Сайншанд сум

2016.03.30

1-р улирал

Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт		Шалгуур үзүүлэлтийн биелэлт
	Арга хэмжээний шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн хүрэх үр дүн	
Нэг: “Стандартчилал, тохирлын үнэлгээг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:			
1.1 Нийгэм дэх бүх нийтийн стандартын мэдлэгийг дээшлүүлэх талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах	Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр үндэсний болон олон улсын стандарт, баталгаажуулалтын ажил, үйлчилгээний талаар ярилцлага, мэдээлэл өгөх	Байгууллагын үйл ажиллагааны талаар иргэдийн мэдлэг, мэдээлэл дээшилсэн байна.	Аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчдийн дунд “Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал” сэдвээр уулзалт, ярилцлагыг зохион байгууллаа. Уулзалтанд Хамарын хийдэд бизнес эрхэлдэг иргэд болон зочид буудал, жуулчны баазын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, байгууллага, иргэд оролцсон байна. Тус уулзалтанд Баталгаажуулалтын шинжээч Х. Оюу-Эрдэнэ, П. Энх-Отгон нар Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт болон Монгол Улсад даган мөрдөж байгаа стандартын талаар мэдээлэл өглөө.
1.2 Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах	Аймгийн хэмжээнд “Цагаан сар – 2016”, “Дорноговь түншлэл – 2016” бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, шилдэг бүтээгдэхүүн шалгаруулах	Орон нутгийн онцлогтой бүтээгдэхүүн тодорхойлох, ард иргэдийг аюулгүй хүнсээр хангах	Дорноговь аймгийн Стандартчилал, хэмжилзүйн хэлтэс нь “ЦАГААН САР-2016” үзэсгэлэн худалдааг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран амжилттай зохион байгууллаа. Тус үзэсгэлэн худалдаанд төв хөдөөгийн 100 гаруй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид оролцон 500 гаруй төрөл зүйлийн бүтээгдэхүүнээ танилцуулсан байна. Үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалтын нийт 39 сая гаруй төгрөгийн борлуулалт хийсэн бөгөөд худалдан авагчдын идэвхийг нэмэгдүүлэх үүднээс 20000 төгрөгний худалдан авалт бүрт сугалааны эрх олгон урамшуулалт сугалаат худалдааг зохион байгуулж 100 гаруй иргэн азтанаар тодорч, бүтээгдэхүүн үйлчилгээгээ аймгийн иргэдэд сурталчилан ажиллав. Үзэсгэлэнд оролцогчдоос Шилдэг бүтээгдэхүүн, Шилдэг баялаг бүтээгчийг шалгаруулан өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшууллаа. Шилдэг бүтээгдэхүүнд: иргэн Х.Алтан-Одын “Хүүхдийн үсний гоёл”-ын

ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭС

			багц Шилдэг баялаг бүтээгч: иргэн А.Даваадоржийн монгол гэр, гэрийн тавилга модон эдлэл тус тус шалгарсан байна.
	““Дорноговь түншлэл-2015”, “Шилмэл мал-2015” үзэсгэлэн худалдаа, аймгийн ажил мэргэжлийн аварга тогооч шалгаруулах уралдаан зохион байгуулах тухай”		
1.3 Баталгаажуулалтын албыг ээлжит итгэмжлэлд хамруулах	Олон улсын MNS ISO/ IEC 17065:2013 “Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээний баталгаажуулалтын байгууллагад тавих шаардлага”стандартын дагуу чанарын гарын авлага боловсруулна.	Итгэмжлэлийн хүрээний дагуу “Итгэмжлэлийн гэрчилгээ” авсан байна.	Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын Чанарын гарын авлагыг Олон улсын MNS ISO/ IEC 17065:2013 “Тохирлын үнэлгээ- Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээний баталгаажуулалтын байгууллагад тавих шаардлага” стандартын дагуу бэлтгэн явуулж, СХЗГ-ын Итгэмжлэлийн ахлах мэргэжилтэн З.Мөнхбат, Нэргүйсайхан нар 2016 оны 3дугаар сарын 5-6 өдрүүдэд ирж үнэлгээ хийж ажилласан байна.
			Эхний улирлын байдлаар экспортын бүтээгдэхүүн 3 аж ахуй нэгжид 2 төрлийн (<i>мөнгөний хүдэр, жонш, хэвийн боов, еэвэн</i>) бүтээгдэхүүнийг баталгаажуулан 4 <i>тохирлын гэрчилгээ</i> олгосон байна.
1.5 Дотоодын бүтээгдэхүүний баталгаажуулалт	Орон нутагт үйлдвэрлэж байгаа заавал баталгаажуулалтанд хамрагдах 5 нэр төрлийн бүтээгдэхүүн хамруулж 10 аж ахуй нэгжид гэрчилгээ олгоно.	Ард иргэд чанар стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээ авах болно.	Орон нутагт үйлдвэрлэж байгаа 2 төрлийн (<i>цэвэршүүлсэн ус, бууз бани,</i>) бүтээгдэхүүн баталгаажуулж 1 аж ахуй нэгж, 2 иргэнд баталгаажуулалтын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн <i>тохирлын гэрчилгээ</i> олгосон.
1.6 Үйлчилгээний баталгаажуулалт	төрлийн үйлчилгээг хамруулан 13 аж ахуй нэгж, иргэн, байгууллагад Баталгаажуулалтын зөвлөлийн хурлын шийдвэрээр тохирлын гэрчилгээ олгоно.		Монгол улсын Засгийн газрын тогтоолын дагуу заавал баталгаажуулалтанд хамрагдах 16 төрлийн үйлчилгээний дагуу Дорноговь аймгийн 7 төрлийн (<i>Хүнсний дэлгүүр, дэн буудал, гуанз, Хүнсний мухлаг, кафе, интернэт кафе, супермаркет, худалдааны төв</i>) үйлчилгээнд 37 аж ахуй нэгж, иргэнд Баталгаажуулалтын зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу <i>тохирлын гэрчилгээ</i> олголоо.
1.7 Аж ахуй нэгж, байгууллага, иргэнд сургалт зохион байгуулах	Дотоодын бүтээгдэхүүний сав баглаа боодол, хаяг шошгоны талаарх сургалтыг Сайншанд сумын баялаг бүтээгчдэд хийнэ.Сургалтанд нийт 45 хүн хамрагдана.	Бэлэн бүтээгдэхүүний чанар сайжирч, хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал хангагдана.	Шинээр батлагдсан болон хүчингүй болсон стандарт, Шинэчлэгдсэн үнэ зэргийн талаар Байгууллагын facebook, цахим хаягаар мэдээлэл хийсэн байна. 1. Саяхан Сайншандад зохион байгуулагдсан Дорноговь, Говьсүмбэр аймгийн хоёрдугаар тойргийн Тахарын албан хаагчдын нэгдсэн сургалт зөвлөгөөнд тус хэлтсийн баталгаажуулалтын шинжээч Х.Оюу-Эрдэнэ,

			<p>Г.Шинэчимэг нар оролцож, өөрсдийн байгууллагын холбогдох хууль тогтоомжууд болон үндэсний болон олон улсын стандарт, Чанарын удирдлагын тогтолцоо /ISO 9001-2010 / - ны стандартын талаар анхан шатны ойлголт, мэдээллийг өгч ажилласан байна.</p> <p>Энэхүү сургалтанд 25 төрийн албан хаагч оролцож, сонирхсон асуултандаа хариулт авчээ.</p> <p>2. Энэ жилийг Баялаг бүтээгчдийг дэмжих жил болгосонтой холбогдуулаад Дорноговь аймгийн Баялаг бүтээгчдийн салбар хорооны анхдугаар сургалт, семинарын үеэр тэдгээрийн үйл ажиллагаанд шаардлагатай стандартын талаар, мөн бүтээгдэхүүний баталгаажуулалтын талаар тус хэлтсийн баталгаажуулалтын шинжээч Г.Шинэчимэг 170 гаруй аж ахуй нэгж, иргэдийн төлөөлөлд мэдээлэл хийж холбогдох асуултанд хариулсан.</p>
<p>Хоёр: “ Хэмжилзүйн баталгаажуулалтын ажлын цар хүрээг өргөжүүлэх, хэмжлийн нарийвчлалыг сайжруулах ” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:</p>			
<p>2.1 Анхдагч болон ажлын эталоныг хадгалах, ашиглах, тэдгээрийг улсын эталонтой харьцуулан дүйлгэж баталгаажуулах</p>	<p>Ажлын дараах эталоныг баталгаажуулна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Масс – 6 ➢ Цахилгаан – 1 ➢ Эзэлхүүн багтаамж – 4 ➢ Даралт – 2 <p>Нийт 13 ширхэг</p>	<p>Нутаг дэвсгэртээ хэмжлийн нэгдмэл байдлыг хангана.</p>	<p>Ажлын нийт 13 ширхэг эталоныг 3 дугаар улиралд баталгаажуулалтанд хамруулна.</p>
<p>2.2 Хэмжилзүйн лаборатори ээлжит итгэмжлэлд хамрагдана</p>	<p>Олон улсын MNS ISO/ IEC 170-25:2007 “ Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага ” стандартын дагуу чанарын гарын авлага боловсруулна.</p>	<p>Итгэмжлэлийн хүрээний дагуу “Итгэмжлэлийн гэрчилгээ” авсан байна.</p>	<p>Хэмжилзүйн лаборатори нь Олон улсын MNS ISO/ IEC 170-25:2007 “ Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага ” стандартын дагуу чанарын гарын авлагыг дахин боловсруулан Стандартчилал, хэмжилзүйн газарт хүргүүлсэний дагуу итгэмжлэлийн ахлах мэргэжилтэн З.Мөнхбат энэ оны эхний улиралд ирж газар дээр нь үнэлгээ хийсэн байна.</p>
<p>2.3 Цулын хэмжих хэрэгсэл баталгаажуулах</p>	<p>Аж ахуй нэгж, иргэн, байгууллагын ашиглаж байгаа 100 ширхэг жин, авто пүү зэрэг хэмжих хэрэгсэл баталгаажуулна</p>	<p>Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээнд ашиглагдаж байгаа</p>	<p>Дорноговь аймгийн нутаг дэвсгэр дээр худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй 17 аж ахуйн нэгж, байгууллага 28 хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эзэмшилд ашиглагдаж байгаа нийт 70 ш хэмжих хэрэгслийг улсын баталгаажуулалтад хамрууллаа.</p>

ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭС

2.4 Цахилгаан хэмжих хэрэгсэл баталгаажуулах	Айл өрх, албан байгууллагын цахилгааны тоолуур 200 ширхэгийг баталгаажуулав.	бүх хэмжих хэрэгсэл баталгаажсан байна.	Цахилгаан хэмжих хэрэгслийг баталгаажуулахдаа Улаанбаатар Төмөр замын Эрчим хүч ус хангамжийн 2 дугаар ангийн цахилгаан хэмжих хэрэгслийн тохируулгын лабораторитой хамтран ажиллах гэрээ байгуулан 1-р улирлын байдлаар 3 фазын цахилгаан механик тоолуур 1 ширхэг, 1 фазын электрон тоолуур 5 ширхэг 6 ширхэг цахилгаан тоолуурт ээлжит баталгаажуулалт хийсэн.
2.5 Хий шингэн, эзэлхүүн зарцуулалтын хэмжих хэрэгсэл баталгаажуулах.	Орон нутагт ашиглагдаж байгаа: ➢ 10 ширхэг усны тоолуур баталгаажуулна. ➢ Шатахуун түгээх станцын түгээгүүрийн хошуу 15 ширхэг		2016 оны 1-р улирлын ааеааад бее өдйауиде оуиаебб оудуаиуе иебб 7 өдббүаебб (аабабадаида дийид) аадаеааааббббнаг. Шатахуун түгээгүүрийн станцуудын хэмжих хэрэгсэлд улсын баталгаажуулалт олголоо. Үүнд: Шатахуун түгээгүүр 1 , усны тоолуур 6 ширхэгийг баталгаажуулалт хийсэн байна.
2.6 Даралтын хэмжих хэрэгсэл баталгаажуулах	Даралтын 30 ширхэг манометр баталгаажуулна.		Дорноговь аймгийн “Чандмань- Илч” ОНӨ ХХК –ын Усны тоолуурын лабораторитой гэрээ байгуулсан.
Гурав: “ Хүний нөөцийн чадавхийг сайжруулах, мэргэшүүлэх, байгууллагын дотоод үйл ажиллагааг эрчимжүүлэх ” гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:			
3.1 Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар мэдлэг олгох сургалт	Байгууллагын ажилтнуудыг бүрэн хамруулна.		- СХЗГ-т зохион байгуулсан Итгэмжлэлийн үнэлгээний мэргэжилтэн бэлтгэх сургалтанд тус хэлтсийн баталгаажуулалтын шинжээч Х.Оюу-Эрдэнэ, Г.Шинэчимэг нар хамрагдаж гэрчилгээ гардан авлаа.
3.2 Улсын шалгагч, Баталгаажуулалтын шинжээч нарыг мэргэжлийн сургалтанд хамруулна.	СХЗГ-ын Сургалтын албанаас зохион байгуулж байгаа зарим төрлийн эрх олгох сургалтанд хамрагдана	Хэлтсийн ажилтнуудын ажиллах мэргэшлийн түвшин , ур чадвар дээшилнэ.	- СХЗГ-ийн Сургалтын төлөвлөгөөний дагуу Лаборатори итгэмжлэл, дотоод аудит, Лабораторийн итгэмжлэлд тавигдах шаардлага MNS ISO / IEC 17025 модуль -2 сургалтанд улсын шалгагч П.Энх-Отгон, Б.Түвшинжаргал нар хамрагдсан.

**ИЛ ТОД БАЙДЛЫГ ИЛТГЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ
ХАНГАЖ АЖИЛЛАХ ТУХАЙ ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ**

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
НЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ			
1.1	Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хэлтсийн үйл ажиллагааны эрхэм зорилго, тэргүүлэх чиглэл болон, байгууллагын үйл ажиллагаа, тухайн сарын ажлын төлөвлөгөө, онцлог мэдээллийг мэдээллийн самбартаа тогтмол байршуулж үйлчлүүлэгчид мэдээлж ажиллав. Мөн “Чанарын удирдлагын тогтолцоо” самбар болон Баталгаажуулалтын алба, Хэмжилзүйн лабораторийн мэдээллийн самбарыг шинэчлэн masm.do.gov.mn гэсэн цахим хаягаар байгууллагаас зохион байгуулсан арга, хэмжээ үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тогтмол байршуулан, мэдээллийн ил тод нээлттэй байдлыг ханган ажилласан.	100.0
	Албан хаагчийн ёс зүйн дүрэм	Монгол Улсын төрийн албан хаагчийн эрхэмлэх есөн зүйлийг чандлан мөрдөж, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн гарын авлагыг судлан, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг.	100.0
	Төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь	Төрийн үйлчилгээг иргэдэд хурдан шуурхай хүргэх, нээлттэй байлгах үүднээс ажилтнуудын албан тушаал, овог нэр, утасны дугаарыг багтаасан хаалганы хаягийг байршуулсан.	100.0
	Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт	Баталгаажуулалтын алба, хэмжил зүйн лабораториос үйлчилгээ авахад шаардлагатай баримт бичиг, материалын жагсаалт, баталгаажуулалт, стандартын салбар сангаас үйлчилгээ авахад шаардлагатай материалын жагсаалтыг шинэчлэн байршуулж, хэмжилзүйн лабораторийн мэдээллийн самбарыг шинэлэг загвараар хийн үйлчилгээний төлбөрийн шинэчилсэн жагсаалт, холбогдох хууль, тогтоомжийг байршуулсан.	100.0
	Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар	Мэдээллийн самбарт байршуулан иргэд, үйлчлүүлэгчдэд нээлттэй ил тод байдлаар хүргэдэг.	100.0
1.2	Тухайн байгууллагаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Байгууллагын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан үйлчилгээний 60-70%-ийг тухайн орон нутагт нь очиж, үйлчилгээ үзүүлдэг учир ээлжит баталгаажуулалтын үеэр тухайн орон нутгийн баталгаажуулалтанд заавал хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээ, хэмжих хэрэгслийг ээлжит баталгаажуулалтанд хамруулж, иргэд үйлчлүүлэгчдэд хүндрэл чирэгдэлгүй үйлчилж байна.	70

ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭС

1.3	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг иргэдэд үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй өгөх зохион байгуулалтын арга хэмжээ авах	Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хүрээнд үйлчилгээний үнэ хөлсийг тогтоосон шийдвэрүүдийг мэдээллийн самбаруудад байрлуулж, эрхзүйн актуудаар тогтоосноос бусад үйлчилгээнд ямар нэгэн төлбөр хураамж авдаггүй тухай мэдээллийг мэдээллийн самбарт байрлуулсан.	100.0
1.6	Санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах утас буюу хайрцаг /дэвтэр/ ажиллуулан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Санал, хүсэлт өргөдөл, гомдол хүлээн авах хайрцаг, хэлтсийн үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан хэмжил зүйн лаборатори, баталгаажуулалтын албанд байдаг санал хүсэлтийн дэвтэрт ирсэн санал хүсэлтийг тэмдэглэн хүлээн авч хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэсэн.	100.0
1.7	Өргөдөл гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариуг өгч хэвших	Үйл ажиллагаатай холбоотой гомдол ирээгүй болно.	100.0
ХОЁР: ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН ИЛ ТОД БАЙДАЛ			
2.1	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам боловсруулан хэрэгжүүлсэн байх	Байгууллагын хэмжээнд хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байгаа бөгөөд хэрэгжилтийг хянах үнэлэх тусгайлсан журам боловсруулаагүй бөгөөд хэлтсийн хөдөлмөрийн дотоод журам, Төрийн үйлчилгээний ажилтны ажлыг үнэлж дүгнэх, шагнаж урамшуулах журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ын дагуу үнэлж дүгнэж байна. Санхүү, төсвийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар томоохон арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй юм.	90.0
2.2	Байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил тод, нээлттэй байдлыг хангах, арга замыг хүний нөөцийн стратегид тусгасан байх	Хэлтсийн хүний нөөцийн удирдлагын нээлттэй ил тод байдлыг хангаж, хүний нөөцийн үйл ажиллагаанд баримтладаг дүрэм, журам, ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг нээлттэй байдлаар зохион байгуулж ажилласан.	100.0
2.4	Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаар сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас жил бүр авч, дүнг ил тод танилцуулан, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээ авсан байх	Байгууллагын соёл, ажлын зохион байгуулалт, үйлчилгээ үзүүлэх орчны тохижилтод анхаарч, цэвэрлэгээ, үйлчилгээг тогтмол хийж, ажилтнуудын гаргасан санал санаачлагыг дэмжин, үйлчлүүлэгчид чирэгдэл, хүнд сурталгүй үйлчлэх нөхцлийг бүрдүүлсэн. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг санал асуулгын хуудсаар авч, дүнг тайланд хавсаргасан.	100.0
2.5	Сул орон тооны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарласан байх	Ажлын байрны сул орон тоо гараагүй.	-
2.6	Албан хаагчдийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн, зөв, шударга болгох чиглэлээр байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг зохион байгуулсан байх	Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ, Төрийн албаны тухай хууль, хөдөлмөрийн тухай хууль болон хэлтсийн хөдөлмөрийн дотоод журам, СХГ-ын хяналт шинжилгээ-үнэлгээний журмыг баримтлан үнэлж, дүгнэн холбогдох журмын дагуу нэмэгдэл, урамшууллыг олгохдоо хамт олны хурлаар хэлэлцэн, шийдвэрлэдэг журам тогтсон. Ажилтан бүр үйл ажиллагааны тайлангаа хамт олны хуралд тавьж, үр дүнгийн үнэлгээг бүр ажилтны хуралд танилцуулж, урамшуулах, хариуцлаг тооцох тогтолцоог бүрдүүлсэн.	100.0
ГУРАВ. ТӨСӨВ САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДАЛ			
3.1	Төсвийн төслийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлтэй нягт уялдуулсан байх		100.0

ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭС

3.2	Үндэсний аюулгүй байдал болон төрийн нууцтай холбоотойгоос бусад байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төслийг Монгол улсын төсвийн ил тод байдал /www.iltod. / цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага, чөлөөтэй авах нөхцлийг бүрдүүлсэн байх	Ил тод байдлын тухай хууль тогтоомжид заасны дагуу Төсөв, санхүүгийн ил тод байдлын мэдээллийн самбар байршуулж, гадаад дотоод хэрэглэгчдийг төсөв санхүү болон журамд заасан бусад мэдээллээр тогтмол ханган самбарын мэдээллийг сар бүр шинэчлэн ажилласан. Аймгийн цахим хуудсанд хэлтсийн төсөв, санхүүгийн ил тод байдлын мэдээллийг аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст гаргаж, сар бүр мэдээллэж байна. Мөн хэлтсийн төсвийн хуваарь, санхүүгийн үйл ажиллагааны тайлангуудыг өөрийн байгууллагын masm.do.gov.mn сайтын Ил тод байдлын цэсэнд тогтмол байршуулан хэвшээд байна.	100.0
3.3	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангасан байх	Төсөв санхүүгийн мэдээллийн самбарт төсвийн гүйцэтгэл, үйл ажиллагааны сарын орлого, зарцуулалтын мэдээг мэдээллийн самбарт тогтмол байршуулж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг бүрэн бүрдүүлсэн. Мөн СХЗГ болон аймгийн ЗДТГ-т сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, орлого, зарцуулалтын мэдээг гаргаж хүргүүлээ.	100.0
3.4	Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх	Байгууллагын 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээллийн самбарт бүрэн эхээр нь байршуулж, төсөв, санхүүгийн холбогдолтой мэдээллийг аймгийн цахим хуудсанд байршуулахаар заасан хугацаанд нь хүргүүлсэн.	100.0
3.5	Тухайн жилийн батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд энэ тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлөөр хангасан байх	Тухайн жилийн батлагдсан төсөвт таналт хийснийг тухай бүрт нь мэдээллийн самбартаа байршуулан, мэдээллийг тухай бүрт нь хүргэж ажиллаж байна.	100.0
Хэрэгжилтийн хувь			95.0

